




### Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 11.02	
2					
3					

### Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

НОТЛОХ БАРИМТАНД МЭРГЭЖЛИЙН  
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол улсын нутаг дэвсгэр дээр гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийн үед ослын газрын нотлох баримтад мэргэжлийн шинжилгээ, судалгаа хийлгэхээр илгээх, буцааж авах ажиллагааг зохицуулна.

1.2. Шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллага нь осолд орсон агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсгийн тодорхой нэг хэсэгт мэргэжлийн шинжилгээ болон туршилт явуулах шаардлагатай үед гэж үзэхэд агаарын хөлгийн эзэмшигч болон даатгалын байгууллагын талаас албан бичгээр зөвшөөрөл авна.

1.3 Энэхүү журмыг агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах үйл ажиллагааны зааврын 5 бүлгийн заалтын үндэслэн осол, зөрчил гарсан үед ослын газар дээрх агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн, нотлох баримтыг мэргэжлийн судалгаа шинжилгээ судалгаа хийх ажиллагаанд дагаж мөрдөнө.

1.4 Осол, зөрчил гарсан үед ослын газар дээрх агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсэг нотлох баримтыг өөр улс руу илгээж шинжилгээнд явуулах тохиолдолд эд ангийг хурдан шуурхай тээвэрлэн хүргэх, түүнийг буцааж авах ажиллагааг хөнгөвчлөх шаардлагатай.

1.5. Агаарын хөлгийн эд ангийн шинжилгээ нь скайнер электрон микроскоп химийн анализын тусламжтай хийгдэнэ. Шинжилгээ хийх лаборатор нь тусгай зориулалтын аппаратаар тоноглогдсон байх ба мэргэжлийн бэлтгэгдсэн ажиллагсад, тухайн эд ангийн үйлдвэрлэгчийн техникийн хүчин чадал, боломжийг харгалзан үзнэ.

1.6. Шинжилгээний лабораторийн үзлэг нь стандартын туршилтаар хязгаарлагдахгүй, зарим тохиолдолд тухайн эд ангийн (металл, материал, түлш тос) шинж чанарыг тогтоох, дээд зэргийг шалгалт туршилт хийх шаардлага гардаг.

1.7. Шинжлэн шалгалт явуулж буй байгууллага нь шинжилгээний лабораторт агаарын хөлгийн эвдэрсэн болон татгалзсан эд ангийг илгээхдээ түүний талаар аль болох их мэдээллээр хангах ёстой.

1.8. Эд ангийн талаарх дараах мэдээллийг шинжилгээний лабораторт өгнө. Үүнд

- Агаарын хөлөгт суулгасан он, сар өдөр
- Нислэгт ашигласан цаг
- Капитал засварын дараах нислэгт ашигласан цаг
- Өмнө гарсан дутагдал

- Эвдрэл, татгалзалд хүргэж болох өөр бусад бүх мэдээлэл

1.9. Нотлох баримтыг хадгалахын тулд эд ангийг салгах, задлах үед маш болгоомжтой харьцах хэрэгтэй. Аль болох зүсэлгүй задлах хэрэгтэй.

1.10. Цохилт болон татгалзлын үед үлдсэн мөр, будаг зэрэг нь шинжлэн шалгах ажиллагаанд маш чухал байдаг.

### **Хоёр Шинжилгээний лабораторын үзлэг**

2.1 Шинжилгээний байгууллагыг сонгохдоо тухайн эд анги, системийн төрөл шинж, чанараас хамаарна. Шинжлэн шалгагч нь тухайн шинжилгээний байгууллагын шинжилгээ явуулах боломжтой ба тэдгээр шинжилгээний хариу нь шинжлэн шалгах ажиллагаа явуулахад тус дөхөм болохоор аль болох хурдан хугацаанд шийдэх эсэхэд итгэлтэй байх ёстой.

2.2. Хэрвээ томоохон эвдрэл гарсан гэж үзэж байгаа боловч ослын газарт эд мөрийн баримтыг шинжлэх байгууламж ба мэргэжилтнүүд байхгүй бол эд мөрийн баримтыг тохирох байгууламж руу шалгуулахаар явуулна. Шинжилгээний үйлчилгээг зохион байгуулахын өмнө дараах зүйлүүдийг анхаарна.

- Хэмнэлт хийх үүднээс шаардлагатай баримтыг олж тогтоох ажлыг хамгийн боломжит хэмжээнд хязгаарлана.

- Албаны төв байртай ойролцоо байгууламжаас илүү бүс нутагт байрласан байгууламжийг ашиглах нь зүйтэй. Лабораторид шийдвэр гаргахын өмнө ерөнхий шинжлэн шалгагчтай зөвлөлдөх шаардлагатай.

- Эдгээр үйлчилгээг сонгох үедээ гарч болох эрх ашгийн зөрчлийг болгоомжтой тооцох шаардлагатай ба ийм асуудал байгаа бол түүнийг хурдан шуурхай байдал ба зардлаас илүү чухалчлах ёстой.

- Хэдийгээр зөв зорилготой боловч хангалтгүй мэдлэгтэй эсвэл шаардлага хангахгүй тоног төхөөрөмжтэй мэргэжилтнүүд нь шинжлэн шалгах оролдлог хийснээрээ үнэтэй эд мөрийн баримтыг устаж болно гэдгийг анхаарах шаардлагатай.

- Шинжилгээний журам нь буруу юм уу тохиромжгүй байдлын улмаас гарсан баримтын алдааг залруулахын тулд шинжилгээ хийж байгаа газар нь шаардлага хангасан ба чадвартай гэдгийг батлах ёстой. Эргэлзээтэй үед лабораторийн чадварыг шалгатай хүлээнэ.

- Шинжилгээний зорилгоор задаргаа хийх тохиолдолд, ажиллагаа эхлэхээс өмнө түүний бүх талуудыг шалгаж бүртгэх ба задаргаа хийсэн зүйлүүдийн шаардлага хангасан нарийн бүртгэл хийгдэж баталгаажуулна.

- Аливаа шинжилгээ нь эдгээр журамд нийцсэн бөгөөд хүлээн авч болохуйц тайлан дүгнэлтийг хэвлэж баталгаажуулна.

- Лабораторийн үйлчилгээ авахыг хүссэн зохих маягыг ашиглаж, шинжлэн шалгагчийн ажилд саад учруулах юм уу зүй бусаар хязгаарлахгүйгээр шалгалтын зорилгыг нямбай тодорхойлж бичнэ.

### **Гурав. Нотлох баримт болон бусад эд ангийг тээвэрлэх**

3.1. Аливаа тохиролцсон улсууд агаарын хөлгөөр ачаа болон эд ангийг зөөвөрлөхдөө хил, гаалийн асуудлыг түргэвчлэх хялбарчлах зорилгоор агаарын ачаа тээврийн зохих дүрэм журмыг дагаж мөрддөг.

3.2. Агаарын хөлгөөр ачаа болон эд ангийг зөөвөрлөхдөө хил, гаалийн асуудлыг түргэвчлэх, хялбарчлах зорилгоор агаарын ачаа тээврийн зохих дүрэм журмандаа өөрчлөлт оруулахдаа харилцан зөвшилцөнө.

3.3. Харилцан тохиролцсон улсууд нь оруулж ирж байгаа гаргаж байгаа ачаа тээшийг ямар нэгэн саадгүйгээр нэвтрүүлнэ.

3.4. Харилцан тохиролцсон улсууд нь олон улсын аэропорт дээр нээлттэй бүс болон гаалийн агуулах байгуулж, түүнийг өөрсдөө ашиглах ба нөгөө талдаа ашиглах боломж олгож, тодорхой дүрэм журмын дагуу ажиллагаа явуулна.

3.5. Агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсэг, эд ангийг тээвэрлэхдээ тээвэрлэлтийн гэрээлэгч талд хяналтын маягтыг өгч, хүлээн зөвшөөрсөн гарын үсэг зуруулна. Эд анги, нотлох баримтыг хүлээн авснаас эхлээд өмгөөлөгчид нь буцаан явуулах хүртэл тухайн эд ангиудыг шалгах бүх ажиллагаанд шинжлэн шалгах эрх бүхий байгууллагын шинжлэн шалгагч нь биечлэн оролцох ёстой.

3.6. Эд ангиуд нь шинжлэн шалгах ажиллагаанд цаашид хэрэггүй гэж Алба үзсэн үед эд ангийг өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагчийн хүсэлтэнд боломжийн хэрээр нийцүүлэн буцаах шаардлагатай арга хэмжээг авна.

3.7. Эд ангийг хүлээн авсан, буцаасныг бичгээр баримтжуулж өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагчийг хүлээн авсан бичгэн дээр гарын үсэг зуруулна. Нотлох баримтыг хүлээлцэх маягтийг Хавсралт №1-д үзүүлэв.

3.8. Нотлох баримтыг Хавсралт №2-д үзүүлсэн маягтийн дагуу бүртгэнэ.

ШИНЖИЛГЭЭНД ЯВУУЛАХ НОТЛОХ БАРИМТЫГ ХҮЛЭЭЛЦЭХ ХҮСНЭГТ

Эзэмшигч	Төрөл	Нислэгийн нэр	Бүртгэл	Ангилал
Байрлал	Огноо	Хүлээлгэн өгсөн		
		Эд анги	Сэлбэг хэрэгсэл	
Өгсөн Сэлбэгийн нэр		Part Number	Тэмдэглэл	

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн дагуу би дээрх сэлбэг, эд ангийг тус албанд хүлээлгэж өгснийг баталж байна.

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Хүлээн авсан хүний нэр: \_\_\_\_\_ (гарын үсэг)

Хүлээн авсан огноо: \_\_\_\_\_

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн дагуу би дээрх сэлбэг, эд ангийг ( \_\_\_\_\_ ) эзэмшигч болон ашиглагчид шинжилгээний ажиллагаа дууссан тул буцааж хүлээлгэж өгснийг баталж байна.

Шинжилгээний газрыг төлөөлж: Нэр \_\_\_\_\_ (гарын үсэг)

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Буцааж өгсөн огноо: \_\_\_\_\_

